

БАТЛАВ.

ГАДААД ХЭРГИЙН САЙД БӨГӨӨД  
“ДЭЛХИЙН МОНГОЛЧУУД ХӨТӨЛБӨР”-ИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ,  
ХЯНАЛТ ТАВИХ ҮҮРЭГ БҮХИЙ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГА

Л.ПҮРЭВСҮРЭН



Улаанбаатар хот

2016 оны 5 дугаар сарын 16-ны өдөр

**“ДЭЛХИЙН МОНГОЛЧУУД” ХӨТӨЛБӨРИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага
<b>НЭГ. БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙГ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД</b>			
1.	Хилийн чанадад 3 сараас дээш хугацаагаар болон байнга оршин сууж буй иргэдийн нэгдсэн мэдээллий сан бий болгох	2016-2020	ГХЯ ХЗЯ УБСЕГ ХЧМЗ <sup>1</sup>
2.	Хилийн чанадад оршин сууж буй иргэдийн мэргэжил, боловсрол, ур чадварын зэрэг зорилтот сэдэвчилсэн судалгааг хийх	2016-2017	ГХЯ БСШУЯ ХЯ ХЧМЗ
3.	ДТГ-уудад төрийн үйлчилгээг цахимаар хүргэх боломжийг бүрдүүлэх	2016-2020	ГХЯ ХЗЯ
4.	Хилийн чанадад оршин сууж буй иргэдийг шинэчилсэн бүртгэлд бүрэн хамруулах, бичиг баримтгүй, бичиг баримтын зөрчилтэй иргэдийн асуудлыг шийдвэрлэх	2016-2020	ХЗЯ ГХЯ
<b>ХОЁР. ХИЛИЙН ЧАНАДАД БАЙГАА МОНГОЛ ИРГЭДИЙН ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД</b>			
5.	Гадаадад их, дээд сургууль төгсөгчдийг ажлын байраар хангах, гадаадад төгсөгчдийг ажлын байраар хангасан үндэсний болон гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэх тогтолцоо бий болгох асуудлаар судалгаа хийх	2016	ХЯ
6.	Гадаадад ажиллаж, амьдарч байгаад буцаж ирсэн иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоо бүрдүүлэх	2016-2020	ХЯ
7.	Гадаадын иргэншилтэй болсон монгол иргэдийн	2016	ЕТГ

<sup>1</sup> “Хилийн чанад дахь монголчуудын зөвлөл” ТББ

	Монгол Улсад зорчих, оршин суух, бизнес эрхлэх нөхцөлийг хөнгөвчлөх хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх		ХЗЯ
8.	Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийг Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Польш Улс зэрэг улсуудтай эцэслэн тохиролцож байгуулах	2016-2020	ГХЯ ХАХНХЯ
9.	Монгол иргэд олноор оршин сууж байгаа улс орнуудтай нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулах талаар судлах, тэдэнд хүн ам, нийгмийн хамгааллын үйлчилгээг хүртээмжтэй болгох зорилгоор холбогдох судалгаа хийх, төсөл хөтөлбөрүүдтэй хамтарч ажиллах	2016-2020	ГХЯ ХАХНХЯ
10.	Патент, өндөр технологи, инновацийг нутагшуулах чиглэлээр уулзалт, семинар зохион байгуулах	2016-2020	АҮЯ
11.	Патент, өндөр технологи, инновацийг нутагшуулах шинэ санал, санаачлагад бодлогын зээлийн дэмжлэг үзүүлэх	2016-2020	АҮЯ
<b>ГУРАВ.МОНГОЛ ИРГЭДИЙН ХОЛБОО, ИРГЭДИЙН САНААЧИЛГЫГ ДЭМЖИХ АЖЛЫН ХҮРЭЭНД</b>			
12.	Хилийн чанад дахь Монгол иргэд, иргэний байгууллагуудын нэгдсэн мэдээллийн сан бий болгох	2016-2020	ГХЯ ХЗЯ ХЧМЗ ЦӨХ ТББ <sup>2</sup>
13.	Хилийн чанад дахь Монгол иргэдийн ТББ-уудын ээлжит чуулга уулзалтыг зохион байгуулах	2016-2020	ГХЯ ХЧМЗ ДМЧ ТББ <sup>3</sup>
14.	“Монгол орны хөгжилд” чуулга уулзалтууд зохион байгуулах	2016-2020	ГХЯ БСШУЯ ХЧМЗ ЦӨХ ТББ ДМЧ ТББ
15.	Хилийн чанадад байгаа монгол хүүхдүүдэд монгол хэл, ёс заншил, түүх, соёлын чиглэлээр суурь чадамж эзэмшүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх болон сурах бичиг, гарын авлага, хялбаршуулсан сургалтын хөтөлбөр боловсруулах	2016-2020	ГХЯ БСШУЯ ХЧМЗ
16.	Хилийн чанад дахь монгол иргэдийн зохион байгуулах соёл, урлагийн арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх	2016-2020	БСШУЯ ГХЯ БОНХАЖЯ
17.	“Миний Монгол наадам” арга хэмжээг зохион байгуулах	2016-2020	ГХЯ БОНХАЖЯ Үндэсний Их баяр наадмын зохион байгуулах комисс

<sup>2</sup> Цахим Өртөө Холбоо ТББ

<sup>3</sup> Дэлхийн монголчуудын чуулган ТББ

18.	Монгол улсын байгууллага, аж ахуйн нэгжүүдийг олон улсад зохион байгуулагддаг үзэсгэлэн, яармагт хилийн чанадад оршин сууж буй монгол иргэд, монгол иргэдийн холбоод төлөөлөн оролцох боломжийг бий болгох	2016-2020	ГХЯ БОНХАЖЯ АУЯ ХЧМЗ МҮХАҮТ
<b>ДӨРӨВ. МОНГОЛ ХЭЛ, СОЁЛ, УРЛАГ, ЗАН ЗАНШЛЫГ ӨВЛӨГЧ АРД ТҮМНҮҮДИЙН СОЁЛЫН СОЛИЛЦОО, ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ АЖЛЫН ХҮРЭЭНД</b>			
19.	Монгол хэл, соёл, урлаг, зан заншлыг өвлөгч ард түмнүүдтэй харилцах чиглэл, баримтлах бодлогын талаар судалгаа хийх	2016	ГХЯ ДМЧ ТББ
20.	Олон улсын байгууллагад бүртгэлтэй Монголчуудын холбоо байгуулах талаар судалгаа хийх	2016-2017	ГХЯ ДМЧ ТББ
21.	Монгол үндэстний ёс заншил, соёлын үзмэрүүдийг цуглуулан дэлхийн жишигт нийцсэн музей байгуулах санаачлага гарган төсөл хэрэгжүүлэх	2017-2020	БСШУЯ ГХЯ
22.	Хилийн чанадад байгаа монгол угсаатнууд монгол хэл, соёлоо сэргээх, хадгалан өвлөхөд нь дэмжлэг үзүүлэх	2016-2020	ГХЯ БСШУЯ
23.	Монгол туургатан оюутанг Монголын Их Сургуулиудад суралцуулах тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх	2017-2020	БСШУЯ ГХЯ ЦӨХ ТББ
24.	Монгол хэл, соёлын дархлаа, иргэний үндэстний боловсрол, өв уламжлал зэрэг улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын асуудлаар хөрш орнуудтайгаа баримтлах чиглэл боловсруулж мөрдөх	2017-2020	ҮАБЗ-ийн Ажлын алба БСШУЯ ГХЯ
25.	Монгол хэл, соёл, зан заншлыг өвлөн уламжлагч ард түмнүүдийн соёлын солилцоо, харилцаа, хамтын ажиллагаа явуулахад мэдээллийн дэмжлэг үзүүлэх	2016-2020	ГХЯ БСШУЯ
26.	Олон улсын монгол судлалын төвийг Улаанбаатар хотноо байгуулах ажлыг дэмжин ажиллах	2017-2020	ГХЯ БСШУЯ ШУА Монгол судлалын үндэсний зөвлөл